УЛС ТӨР,
ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

МОНГОЛ, ЗӨВЛӨЛТИЙН АРД ТҮМНИЙ НАЙРАМДАЛ, АХ ДҮҮГИЙН БАРИЛДЛАГАА

Р. Отгон
Түүхийн ухааны дэд эрдэмтэн

Шинжлэх ухааны коммунизмыг үндэслэгч К. Маркс, Ф. Энгельс нар «Франц дахь иргэний дайн» хэмээх зохиолдоо «Хуучин мөлжигч нийгмийн оронд энх тайвныг олон улсын зарчмаа болгосон шинэ нийгэм зайлшгүй гарч ирж, хүмүүсийн хоорондын ёс суртахуун, шударга ёсны жирийн хуулиуд улс хоорондын харилцаанд дээд зарчим болно»[1] гэж урьдчилан тодорхойлж байв. Марксизмыг үндэслэгчдийн энэхүү суут сургаал Аугаа их Октябриар эхлэн, капитализмаас социализм, коммунизмд шилжих шилжилт үндсэн агуулга нь болсон манай эрин үед жинхэнэ ёсоор хэрэгжиж байна.

Октябрийн аугаа их социалист хувьсгалын шууд нөлөөгөөр, МАХН ын удирдлагаар 1921 онд Монгол оронд империализм, феодализмыг эсэргүүцсэн ардын хувьсгал ялалтад хүрч, Монголын ард түмэн эрх чөлөө, тусгаар тогтнолоо байлдан олсон нь ялсан пролетарийн орон-Зөвлөлт Орос улстай холбоо тогтоож, тусламж авсантай шууд холбоотой байв.

Ардын засгийн газраас 1921 оны есдүгээр сарын 14-нд дэлхийн олон улсад хандаж гаргасан мэдэгдэх бичигт Монгол Улс тусгаар тогтносон тухай зарлаж, тэдэнтэй найрсаг харилцаа тогтоох хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн билээ. Манай ардын засгийн газар Дундад улстай өшөө хорсголыг агуулан, байлдан дайтах хүсэлгүй байгааг нөгөө талаар Хятадын сюзеренитетийг дахин хүлээж хэрхэвч чадахгүй, гагцхүү одоогийн байгуулсан ардын эрхт засаг л улс орноо удирдах болно гэдгийг ёс төртэй мэдэгдэж, Дундад улстай найрсаг харилцаатай байж улмаар худалдаа арилжааг тэгш эрхийн үндсэн дээр явуулах эрмэлзэлтэйгээ нотолсон байна.

Хөрөнгөтөн орнууд манай улсын найрсаг харилцаа тогтоох тухай саналыг үл хайхран, Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөөгүйгээр барахгүй ардын засгийг түлхэн унагаах бодлого явуулж байв.

Харин ганцхан Зөвлөлт Орос Улс шинэ залуу Монгол Улстай найрамдалт харилцаа тогтоон хөгжүүлэх нь хоёр орны ард түмний болон социалист хувьсгалын эрх ашигт бүрэн нийцнэ гэж үзсэн учир 1921 оны арван нэгдүгээр сарын таванд ардын эрхт Монгол Улс, Зөвлөлт Орос Улсын хооронд хамтран ажиллаж, харилцан туслах зарчим дээр үндэслэсэн хэлэлцээр байгуулагдсан юм.

ЗСБНХАУ энэхүү хэлэлцээрээр манай улсын тусгаар тогтнолыг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн нь олон улсын талбарт шинэ Монгол Улсын халдашгүй дархан эрхийг улам бататгах улс төрийн чухал дэмжлэг болов.

Ардын хувьсгал ялсны дараа манай орны гадаад дотоод байдал туйлын хүнд байсан нөхцөлд ардын хувьсгалыг гадаад дотоодын дайсны өнгөлзлөгөөс хамгаалж, БНМАУ-ын тусгаар тогтносон бүрэн эрхт байдлыг хангахад энэхүү хэлэлцээр асар их үүрэг гүйцэтгэсэн юм.

[1] К. Маркс, Ф. Энгельс. Түүвэр зохиол, II боть, УБ, 1970, 227-р тал

Энэ хэлэлцээр нь түрүүчийн аль ч нийгмийн үед байгаагүй, улс гүрнүүдийн нутаг дэвсгэрийн том, жижиг, хүн амын олон цөөнийг үл харгалзсан, улс хоорондын үнэнхүү тэгш эрх бүхий цоо шинэ маягийн харилцааны үндэс суурийг тавьсанд түүний олон улсын ач холбогдол оршино.

Дэлхийн хөдөлмөрчдийн аугаа их жолоодогч В. И. Ленин, Монголын хувьсгалын удирдагч Д. Сүхбаатар нарын үндэслэсэн Монгол, Зөвлөлтийн ард түмний найрамдалт харилцаа нь пролетарийн интернационализмыг улс хоорондын харилцаанд хэрэгжүүлсэн анхны түүхэн хэлбэр бөгөөд улмаар социалист улсуудын хоорондын жинхэнэ ах дүү ёсны шинэ маягийн харилцааны үлгэр загвар болж өгсөн юм. Манай нам, төрийг үндэслэн байгуулагч Д. Сүхбаатар хэлэхдээ “Манай Монгол Улсын тогтнож хөгжихөд дотоодын хүч нь ард түмэн бөгөөд гадаад байдал дээр түшиг тулгуур нь Зөвлөлийн засагт Холбоот улс мөн. Үүнээс өөр зам байхгүй»[2] гэсэн билээ. Д. Сүхбаатарын холч, мэргэн үгийн үнэн зөв нь амьдралаар батлагдав.

Ардын эрхт Монгол Улсын засгийн газрын хүсэлтээр 1925 он хүртэл манай улсын нутаг дэвсгэрт түр үлдсэн ЗХУ-ын улаан армийн ангиуд шинэ тулгар Монгол Улсын эрх чөлөө, тусгаар тогтнолыг Хятад, Японы түрэмгийлэгчдийн өнгөлзлөгөөс хамгаалах, тус улсын батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэхэд асар их үүрэг гүйцэтгэсэн юм.

Зөвлөлтийн ажилчин, тариачны улаан армийн ангиуд Монгол нутгаас гарч байгаатай холбогдуулан манай ардын засгийн газраас ЗСБНХУ-ын засгийн газарт илгээсэн нот бичигт: «...Манай Монголын олон түмэн ард...дээрэмчний дарлалаас ангижран, одоо үеийн боловсон байдлыг хэрэглэж, эрдэм, аж ахуй, хууль цааз ардын жинхэнэ эрхийг олж бүх байдлыг бадруулахад улаан цэргийн гавъяа нь марташгүй болсон тул, тус улсын олон түмэн ардын өмнөөс...баатар улаан цэрэг ба... СССР улсын засгийн газраа туйлын их баяраа илтгэн мөнх эв найрамдалтай байхыг хамт уламжлан...хүнд бэрх цагуудад харилцан туслалцах ба үүний дотор ямар нэг учраас 1921 онд тохиолдсонтой адил байдал манай улсад тохиолдох болбол манай ард түмэн, засгийн газар нь холбоот улс ба түүний улаан цэргийн тусламжид хатуу батаар итгэж байна»[3] гэж онцлон тэмдэглэсэн юм. Энэ бол эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолыг байлдан олоход мартагдашгүй их ач тус хүргэсэн ЗХУ-ын улаан армийн интернационалч гавъяаг туйлаас хүндэтгэн биширч, цаашдын хувь заяагаа зөвлөлтийн ард түмэнтэй бат холбосон манай ард түмний чин сэтгэлийн үг байлаа.

БНМАУ-ын гадаад байдал нэн түгшүүртэй болж, Японы түрэмгийлэгчид халдан довтлох аюул тулгарч байсан 1930-аад оны дунд үеэр БНМАУ-ын тусгаар тогтнолыг хамгаалан бэхжүүлэх хэрэгт ах дүүгийн ёсоор туслах явдлыг ЗСБНХУ интернационалч үүргээ хэмээн үзэж «Хэрэв Япон Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тусгаар тогтнолд халдан довтлохоор шийдвэрлэвэл бид Монгол Ард Улсад туслах болно. Бид Монгол Улсад 1921 онд тусалсан шиг туслана»[4] гэж дэлхий дахинд мэдэгд сэн нь Японы түрэмгийлэгчдэд хатуу сануулга болж байв.

1934 оны харилцан туслах тухай Монгол, Зөвлөлтийн ам хэлэлцээр болон 1936 оны гуравдугаар сарын 12-нд байгуулсан Монгол, Зөвлөлтийн хооронд харилцан туслах тухай протокол гэрээ нь БНМАУ,

[2] «Үнэн», 1986.1.4.
[3] «Үнэн», 1986.1.4.
[4] Мөн тэнд

ЗСБНХУ-ын хооронд тогтсон ах дүүгийн найрамдалт харилцааг улам зузаатгаж, улс орны маань тусгаар тогтнолыг сахин хамгаалах явдлыг найдвартай баталгаатай болгосон билээ.

Зөвлөлт засгийн газар уг гэрээ ёсоор хүлээн авсан үүргээ ариунаар биелүүлж Монгол Улсын хил хязгаарыг өөрийн хил хязгаар шигээ хамгаалахаар өөрийн улаан армийн ангиудыг манай оронд ирүүлэхийн хамт БНМАУ-ын батлан хамгаалах хүч чадлыг зузаатгахад их тусламж үзүүлэв. Халх голын районд Японы милитаристуудын өдөөсөн түрэмгий халдлагыг Монгол, Зөвлөлтийн цэрэг няцаан Монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолыг авран гандан бууршгүй гавьяа байгуулсан билээ. Аугаа их эх орны дайны жилүүдэд нийтийн дайсны эсрэг хийсэн зөвлөлт, Монголын ард түмний хамтын тэмцэл нь манай хоёр ард түмний найрамдал, хамтын ажиллагааны бат бэхийн шалгуур болов. Дэлхийі II дайнд байгуулсан зөвлөлтийн ард түмний аугаа их ялалт нь БНМАУ-ын тусгаар тогтнолыг бэхжүүлэн аюулгүй байдлыг хангаж социалист бүтээн байгуулалтын үйлсийг энх тайван байдалд өрнүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлж өгсөн юм.

БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд 1946 онд байгуулсан найрамдал, хамтын ажиллагаа, харилцан туслалцах тухай гэрээ болон эдийн засаг, соёлын талаар хамтран ажиллах хэлэлцээр нь монгол, Зөвлөлтийн ард түмний эвдэршгүй бат бэх, ленинч найрамдлын түүхэнд баялаг үйл явдлуудын дотор онцгой байр суурь эзэлдэг юм. Энэ Гэрээнд 1921 оны монгол зөвлөлтийн анхны хэлэлцээр, 1936 онд байгуулсан харилцан туслалцах Протоколын гол үндэслэлүүд улам гүнзгийрэн, БНМАУ, ЗХУ -ын харилцааны хөгжилд шинэ үеийг нээсэн билээ. Уг Гэрээ нь манай хоёр орны төдийгүй, социалист бусад орны энх тайван, аюулгүй байдлыг хангах эрх ашигт бүрэн дүүрэн нийцэж байна. Гэрээний хоёрдугаар зүйлд: «Бүгд Найрамдах Монгол Ард Улс ба Зөвлөлийн засагт Нийгэм Журамт Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн газрууд нь энэхүү гэрээ тогтоосон хоёр улсын аль нэгэнд цэргийн довтолгоон тохиолдвол бие биендээ аливаа нэгэн тусламж, түүний дотор цэрэг зэвсгийн тусламж үзүүлэх үүргийг тус тус хүлээнэ»[5] гэж заасан юм.

БНМАУ, ЗСБНХУ-ын засгийн газрын хооронд байгуулсан эдийн засаг, соёлын талаар хамтран ажиллах хэлэлцээрт манай хоёр орны уламжлалт нягт хамтын ажиллагааг эдийн засаг, соёлын бүх салбарт улам өргөтгөн бэхжүүлэх үндсийг тодорхойлжээ.

Монгол, Зөвлөлтийн 1946 оны гэрээ хэлэлцээр нь БНМАУ-д капиталист биш хөгжлийн замын ялалтыг хангах, социализм амжилттай байгуулах чухал хүчин зүйл болсон улс төр, эдийн засгийн төдийгүй, Алс Дорно дахинд аюулгүй байдлыг хангах, бүх нийтийн энх тайвныг хамгаалахад тус дөхөм үзүүлсэн олон улсын чухал ач холбогдолтой болсон юм.

Дээрх гэрээ, хэлэлцээрийн үндсэн дээр БНМАУ, ЗХУ-ын улс ардын аж ахуй, соёл, шинжлэх ухааны байгууллагын хооронд хэлэлцээр байгуулагдаж, хоёр орны худалдаа байнга өсөн нэмэгдэж, хамтын ажиллагаа аажмаар иж бүрэн шинж чанартай болов.

1946 оны Гэрээ, хэлэлцээрийн интернационалч зарчимд үндэслэсэн манай хоёр орны үр бүтээлт нягт хамтын ажиллагаа, ЗХУ-ын сэтгэл харамгүй тусламж нь социалист Монгол орны аж үйлдвэрийг хөгжүүлэх, ардын хувийн аж ахуйтныг хоршоолох, соёлын хувьсгал хийх зэрэг тус

[5] БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл, I боть, 1964 он, 37-р тал.

улсад социализмын үндсийг байгуулах түүхэн зорилтыг амжилттай хэрэгжүүлж, БНМАУ-ыг мал аж ахуйн орноос хөдөө аж ахуй-аж үйлдвэрийн орон болгон хувиргахад шийдвэрлэх хүчин зүйл болсон юм.

Дэлхийн социализмын систем бүрэлдэн тогтож олон улсын шинэ маягийн харилцааны хүрээ тэлэн өргөжсөн нь БНМАУ-ын гадаад улс төр, Эдийн засаг, соёл-шинжлэх ухааны харилцаанд түүхэн шинэ нөхцөлийг бий болгосон билээ.

БНМАУ, ЗХУ-ын нийгэм, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан-техникийн түргэн хөгжил, тал бүрийн хамтын ажиллагааны баялаг уламжлал, цаашид өргөжих их ирээдүй болон олон улсын харилцаанд гарсан өөрчлөлтүүдийг харгалзан 1946 оны гэрээг 1966 онд шинэчлэн байгуулснаар хоёр орны найрамдалт харилцаа шинэ дээд шатанд гарч, хэлбэр агуулга нь өргөжин баяжиж хоёр орны хамтын ажиллагаа, Монгол, Зөвлөлтийн ард түмний ойртон нягтрах процесс улам гүнзгийрэх хэтийн сайхан төлөвийг нээсэн юм. Энэхүү гэрээ нь олон улсын улс төрийн уур амьсталыг эрүүлжүүлэх, Ази тивийн улс гүрнүүдийн хооронд сайн хөршийн харилцаа, харилцан ашигтай хамтын ажиллагаа, итгэлцлийг бэхжүүлэх, Дэлхийн бөмбөрцгийн энэ бүсэд империалист түрэмгийллийн аюул заналыг сэрэмжлэн зайлуулах үйл хэрэгт олон улсын чухал ач холбог долтой үүрэг гүйцэтгэж байна.

Гэрээний үзэл санаа Монгол, Зөвлөлтийн байнга өргөжин хөгжиж байгаа олон талт хамтын ажиллагаанд бодит биеллээ олж, үр шимээ өгч ирсний дүнд манай орны эдийн засаг, нийгмийн хөгжил улам түргэсч, ард түмний аж байдал, соёлын түвшин цуцалтгүй дээшилж БНМАУ-ын олон улсын байр суурь нэр хүнд ихээхэн өссөөр байгаа нь ленинч шинэ маягийн харилцааны бодит үр дүн юм.

Монгол, Зөвлөлтийн харилцаа бол дэлхийн социализм бүрэлдэн тогтож, улс түмэн найрамдал, хамтын ажиллагааны замаар харилцаагаа өргөжүүлж, хамтран ажиллахын үлгэр дууриалыг олон улсын амьдралд нотлон харуулсан шинэ маягийн харилцааны тулгын чулуу нь болсон билээ. Үүний дүр загвар нь социалист хамтын нөхөрлөлийн орнуудын Найрамдалт харилцаа, эвдэршгүй бат холбоо, нягт хамтын ажиллагаа юм. Тийм ч учраас улс хоорондын шинэ маягийн харилцааны гол зарчим пролетарийн интернационализм нь агуулга, цар хүрээгээ баяжуулан гүнзгийрүүлж, өргөжин тэлж социалист орнуудын нийтлэг зарчим болж хөгжихөд Монгол, Зөвлөлтийн харилцааны бодит туршлага түүхэн замнал дорвитой хувь нэмэр оруулсан гэж үзэх бүрэн үндэстэй юм.

Монгол, Зөвлөлтийн уламжлалт найрамдал, бүх талын хамтын ажиллагааны өгөөмөр сайхан үр шимийг цаг ямагт мэдэрч байдаг манай ард түмэн энэ найрамдлыг эрхэм дээд бахархал, хувьсгалт их ололтоо гэж үздэг.

МАХН-ын XVIII их хурал «Зөвлөлт Холбоот Улсын Коммунист Нам, Зөвлөлтийн ард түмэнтэй тогтоосон найрамдал, хамтын ажиллагааны харилцаагаа хойшид ч хэлбэрэлтгүй бэхжүүлж гүнзгийрүүлэхэд бидний нэн тэргүүний зорилт оршино.

Зөвлөлт Холбоот Улстай тогтоосон холбоо, найрамдал, ах дүүгийн барилдлага бол социализм байгуулах замаар бидний давшингуй хөгжихийн найдвартай баталгаа мөн» гэж дүгнэсэн нь монголын ард түмний хүсэл эрмэлзлийг илэрхийлж, зорилтыг тодорхойлсон юм.

Марксизм-ленинизмийг удирдлага болгосон МАХН-ын зөв мэргэн удирдлага, Монголын ард түмний бүтээлч хөдөлмөр, ЗХУ-ын өгөөмөр тусламжийн үр дүнд БНМАУ социализмын замаар урагшлан давшингуй хөгжиж байна.

Манай оронд сүүлийн хорь гаруйхан жилийн дотор Дархан, Эрдэнэт, Бага нуур, Хөтөл , Бор-Өндөр гэсэн үйлдвэрийн шинэ төвүүд бий боллоо.

Өнгөрсөн дөчин жилд манай улсын нийгмийн үйлдвэрлэлийн нийт бүтээгдэхүүн 15 дахин, үндэсний орлого 11,5 дахин өслөө. Энэ бол манай хөгжлийн асар их хурдцыг гэрчилж байгаа бөгөөд ингэж хөгжихийн эх үндэс нь монгол, Зөвлөлтийн аугаа их найрамдлын үр шимд байдаг гэж манай ард түмэн зүй ёсоор үнэлж үздэг.

БНМАУ, ЗСБНХУ-ын эдийн засгийн салбарын хамтын ажиллагааны үр дүн үнэхээр бахдам юм. Зөвхөн сүүлийн хорин жилд л ЗСБНХУ ын техник-эдийн засгийн тусламжтайгаар манай улсын улс ардын аж ахуйн 600 гаруй байгууламжыг барьж байгуулан ашиглалтад өгсөн юм. Эдгээр үйлдвэр аж ахуйн газар манай орны эдийн засагт зонхилох байр эзэлж байгааг ч тэмдэглэх хэрэгтэй. Жишээ нь Улаанбаатар хотын IV цахилгаан станц өнгөрсөн онд миллиард гаруй киловатт эрчим хүч гаргасан нь 25 жилийн өмнө манай улсын гаргаж байсан эрчим хүчнээс даруй арав дахин их байна. Энэ бол ЗСБНХУ-ын тусламжтайгаар барьж байгуулсан өгөөж ихтэй олон үйлдвэрийн газрын зөвхөн ганц л жишээ юм.

ЗХУ-ын техник-эдийн засгийн туслалцаатайгаар барьсан буюу шинэчлэн өргөтгөсөн үйлдвэрүүдэд одоо манай орны аж үйлдвэрийн ихэнх бүтээгдэхүүн, түүний дотор боловсруулж байгаа цахилгаан эрчим хүчний 95 гаруй хувь, олборлох байгаа нүүрсний 92 хувь, барилгын материалын 70 гаруй хувь, зэс молибдены баяжмал, угаасан ноос, багсармал тэжээл, ээрмэл, сүлжмэл эдлэлийн 100 хүртэл хувийг үйлдвэрлэж байна.

Дэлхийн зэс молибдены хамгийн том 10 үйлдвэрийн нэг болсон Эрдэнэтийн зэс молибдены уулын баяжуулах Монгол-Зөвлөлтийн хамтарсан үйлдвэр төслийн бүрэн хүч чадлаараа ажиллаж, «Монгол-совцветмет» аж ахуйн хамтарсан нэгдлийн үйл ажиллагаа өргөжиж, хүч чадал нь нэмэгдэж байна.

ЗХУ-аас БНМАУ-д 1981 — 1985 онд үзүүлсэн техник-эдийн засгийн тусламж, харилцан нийлүүлсэн барааны хэмжээ урьдах таван жилийнхээс хоёр дахин өслөө. Өнгөрсөн таван жилд ЗХУ-ын тусламжаар хөдөө аж ахуй, түлш, эрчим хүч, уул уурхай, хөнгөн хүнс, барилгын материалын үйлдвэр, Тээвэр холбоо, нийтийн аж ахуй, соёл, эрүүлийг хамгаалах салбарын 150 орчим барилга байгууламжийг иж бүрнээр барьж ашиглалтад оруулав. Үүний дотор уул уурхайн баяжуулах «Эрдэнэт» үйлдвэрийн I, IV ээлж, Бага нуурын нүүрсний уурхайн эхний ээлж, Хөтөлийн цемент шохойн үйлдвэр, Эрдэнэтийн хивсний үйлдвэр, болон соёл-ахуйн бусад барилга байгууламж орж байна. ЗХУ-ын тусламжтайгаар хот, хөдөөд 800 гаруй мянган хавтгай дөрвөлжин метр талбай бүхий орон сууцыг соёл-ахуйн байгууламжийн хамт барилаа. Малын хашаа, атрын болон тэжээлийн аж ахуй, сүүний механикжсан ферм, трактор засварын газар зэрэг хөдөө аж ахуйн олон барилга байгууламжийг барьж байгуулав. Улаанбаатар хотод өнгөрсөн таван жилд IV цахилгаан станц, ээрмэлийн үйлдвэр, талх, чихрийн комбинат, барилгын модон эдлэл, сүү, савангийн үйлдвэр, П. Н. Шастины нэрэмжит Клиникийн III эмнэлэг, Монголын пионер сурагчдын ордон зэрэг үйлдвэр, соёл ахуйн барилга байгууламж ашиглалтанд орлоо. Нийслэл хотын нисэх онгоцны буудлын шинэ барилга баригдаж, троллейбусны шугам барих бэлтгэл ажил хийгдэж байна.

Манай хоёр улсын ах дүүгийн харилцаа, ган бат найрамдал хамтын ажиллагааг улам хөгжүүлэн бэхжүүлэхэд МАХН-ын Төв Хорооны

ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэр гүүлэгчдийн дарга Ж. Батмөнх, ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга М. С. Горбачёв нарын 1985 оны наймдугаар сарын уулзалт шинэ үеийг нээж, найрамдал, хамтын ажиллагааны түүхэн зорилтыг тодорхойлон заасан билээ. Уг уулзалтын үеэр гарын үсэг зурсан БНМАУ, ЗСБНХУ-ын эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааг 2000 он хүртэл хөгжүүлэх урт хугацааны программ нь манай хоёр орны харилцааг хөгжүүлэн гүнзгийрүүлэхэд шинэ чухал үе шат боллоо.

ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга М. С. Горбачёв уг программыг тодорхойлж хэлэхдээ, энэ бол улс төрийн томоохон ач холбогдолтой баримт бичиг юм. Түүнийг хэрэгжүүлэх нь эдийн засгийн потенциалыг өсгөх, хөдөлмөрчдийн аж байдлыг дээшлүүлэхийн тулд зөвлөлт, монголын харилцааны бололцоо нөөцийг бүрэн ашиглах, бидний хүч чармайлт, туршлага, нөөц бололцоо, мэдлэгийг үр ашигтай нэгтгэх бололцоо олгоно гэж тэмдэглэсэн билээ. Энэ программ нь манай хоёр орны үр бүтээлт хамтын ажиллагааг өргөжүүлэн гүнзгийрүүлэх асуудлыг анх удаа иж бүрнээр нь, урт хугацааг хамруулан авч үзсэн нийгэм, улс төрийн онцгой ач холбогдолтой баримт бичиг мөн.

«...урт хугацааны программыг амжилттай хэрэгжүүлснээр БНМАУ-ын эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн потенциал шинэ өрнөлтөд хүрч...социализмын материал техникийн бааз байгуулж дуусгахад шийдвэрлэх алхам хийгдэх болно» гэж нөхөр Ж. Батмөнх МАХН-ын Төв Хорооны XI бүгд хурал дээр уг программыг үнэлж хэлсэн юм.

Энэхүү программ нь ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын шинжлэх ухаан техникийн дэвшлийн 2000 он хүртэлх цогцолбор Программтай нягт уялдаа холбоотой бөгөөд манай улсын эдийн засгийн хөгжлийг Европын социалист орнуудын хөгжлийн түвшинтэй ойртуулахад зохих хувь нэмэр оруулж, БНМАУ-ын эдийн засгийн хөгжлийг түргэтгэхийн хамт эдийн засгийн социалист интеграцид оролцох манай улсын оролцоог цаашид өргөтгөх хэтийн сайхан төлөвийг нээж байна. Ийнхүү монгол, зөвлөлтийн найрамдал бол ард түмний төлөө, тэдний сайн сайхны төлөө найрамдал мөн.

Манай найрамдал хоёр орны ард түмний өдөр тутмын амьдралд бэхжин батжиж, тэдний бүтээлч хөдөлмөрөөр гагнагдаж, МАХН, ЗХУКН ын байнгын анхаарал халамжаар улам цэцэглэн хөгжиж байдаг.

Эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн талаар 1986—1990 онд хамтран ажиллах тухай ЗХУ, БНМАУ-ын Засгийн газар хоорондын 1986 оны Нэгдүгээр сард байгуулсан хэлэлцээрийн дагуу шинэ таван жилд манай хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагаа хөдөө аж ахуй, ялангуяа мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэх, хүн амын хүнс, өргөн хэрэглээний барааны хангамжыг сайжруулах, олборлох болон боловсруулах үйлдвэр, түлш эрчим хүчний цогцолборыг түлхүү хурдацтай хөгжүүлэх, барилгын үйлдвэрийг бэхжүүлэх, экспортын потенциалыг бүх талаар нэмэгдүүлэх зэрэг манай орны эдийн засгийн эн тэргүүний зорилтыг шийдвэрлэхэд чиглэх болно. Энэ таван жилд Монгол-Зөвлөлтийн хамтын ажиллагааны барилга байгууламж, хэрэгжүүлэх арга хэмжээний тоо 1981—1985 оныхоос 1,5 дахин нэмэгдэх юм. Үйлдвэр, аж ахуйн газрыг байгуулах, өргөтгөх, хамтарсан үйлдвэрүүдийг хөгжүүлэх, шинжлэх ухаан-техникийн ололтыг нэвтрүүлэхэд хамтын ажиллагааг чиглүүлж, хөрөнгө хүчийг төвлөрүүлэх

болно. ЗХУ-ын тусламжтайгаар нэг сая гаруй хавтгай дөрвөлжин метр талбайтай соёл ахуйн барилга байгууламж бүхий орон сууц барина.

БНМАУ-ыг тунхагласны 60 жилийн ойг тохиолдуулан зөвлөлтийн ард түмнээс бэлэг болгон зарим барилга байгууламж барих тухай Монгол-Зөвлөлтийн засгийн газар хоорондын 1984 оны хэлэлцээрийн дагуу ЗХУ-аас энэ таван жилд Сүхбаатар, Сайншанд хотод эмнэлэг, Дархан, Сайншанд, Сүхбаатар хотод сургууль, Улаанбаатар хотод 200 ортой гэмтлийн эмнэлэг, 50 мянган хавтгай дөрвөлжин метр талбайтай соёл ахуйн барилга байгууламж бүхий орон сууц, радио релейн шугам зэрэг улс ардын аж ахуйн хэд хэдэн чухал байгууламжыг монголын ард түмэнд бэлэг болгон барьж өгнө.

Түүхт гэрээний дөчин жилийн ойн он бол ЗХУКН-ын XXVII их хурал, МАХН-ын XIX их хурлын жилд болж байгаагаараа онцлогтой юм.

ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга М. С. Горбачевын тавьсан улс төрийн илтгэлийг хэлэлцэн сайшааж, намын шинэчлэн боловсруулсан программ, өөрчлөлт оруулсан дүрэм, ЗХУ-ын эдийн засаг нийгмийг XII таван жилд болон 2000 он хүртэл хугацаанд хөгжүүлэх үндсэн чиглэлийг баталсан ЗХУКН-ын XXVI их хурал нь олон улсын асар их ач холбогдол бүхий түүхэн үйл явдал боллоо. Эдгээр баримт бичиг марксист-ленинист онолын сэтгэлгээг бүтээлчээр хөгжүүл байгаагийн сайхан жишээ, ЗСБНХУ-ын хөгжлийн амин чухал асуудал, Олон улсын амьдралын зангилаа асуудлыг шийдвэрлэхэд шинжлэх ухааны үүднээс хандаж байгаагийн үлгэр жишээ мөн.

Нийтийн тэмцэлд та бүхний ойрын холбоотон, хамтран зүтгэгч, болсон бид эдгээр баримт бичгийн заалтад баярлан зоригжиж байна»[6] гэж МАХН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ж. Батмөнх ЗХУКН-ын XXVI их хурал дээр хэлсэн билээ.

ЗХУКН-ын Төв Хорооны Улс төрийн илтгэлд ЗХУ-ын нийгэм эдийн засгийн хөгжлийн бодит байдлыг гүнгүнзгий шинжлэн дүгнээд түүнийг чанарын шинэ түвшинд хүргэн хурдасгах, шинжлэх ухаан-техникийн Дэвшилд тулгуурлан улс ардын аж ахуйг шинэчлэн төгөлдөржүүлэхийг зааж, дэлхий дахины байдлын үндсэн гол асуудлуудад чухамхүү ленинч ёсоор бүтээлчээр хандаж, улс төрийн мэргэн бодлого боловсруулахын үлгэр жишээг үзүүллээ. Олон улсын хөгжлийн өнөөгийн шатны онцлоггийг харгалзан бодит байдалд бүтээлч дүн шинжилгээ хийсний үндсэн дээр бүх нийтийг хамарсан олон улсын аюулгүй байдлын систем байгуулах үндсэн зарчмыг цэрэг, улс төр, эдийн засаг, нийгмийн салбарт зүйлчлэн боловсруулсныг их хурлын индрээс ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга М. С. Горбачев дэлхий дахинд тунхаглалаа. «Дайныг улс хоорондын улс төр, эдийн засгийн зөрчил, үзэх суртлын маргааныг шийдвэрлэх хэрэгсэл гэж үзэхийг социализм үг дуугүй няцаадаг. Дэлхийг зэр зэвсэггүй болгож, ард түмэн бүр хөгжлийн зам, аж төрөх ёсоо чөлөөтэй сонгон авдаг дэлхийг цогцлон байгуулах нь манай эрхэм дээд зорилго мөн. Энэ бол коммунист үзэл суртал, түүний зан суртахууны үнэт зүйлийн энэрэнгүй ёсны илрэл мөн. Тиймээс цөмийн дайн гарах аюул, зэвсэглэлээр хөөцөлдөхийн эсрэг, бүх нийтийн энх тайвныг сахин хамгаалж бэхжүүлэхийн төлөө тэмцэл олон улсын тавцанд намаас цаашид явуулах үйл ажиллагааны гол чиглэл хэвээр байх болно»[7] гэж нөхөр М. С. Горбачев мэдэгдэв.

[5] «Үнэн». 1986.2.28.
[7] «Үнэн», 1986.2.26.

Коммунистуудын их чуулгад нөхөр М. С. Горбачевын тавьсан ЗХУКН-ын Төв Хорооны улс төрийн илтгэл нь цар хэмжээ, гүн агуулга, бүтээлч шинэлэг чанар, ленинч арга барилаараа шинжлэх ухааны коммунизмын онол, практикийг зүй ёсоор баяжуулаа.

ЗХУКН-ын Программ Ленин, ленинчүүдийн намын онолын сэтгэлгээний гарамгай ололт, шинжлэх ухааны коммунизмын томоохон бүтээл байдаг билээ. К. Маркс, Ф. Энгельс нар бүтээж, В. И. Лениний үргэлжлүүлэн хөгжүүлсэн шинжлэх ухааны коммунизмын онолыг ЗХУКН-ын Программ улам баяжуулж, шинэ шатанд гаргасаар ирсэн юм.

ЗХУКН-ын шинэчлэн боловсруулсан программ нь марксизм-ленинизмийг бүтээлчээр хөгжүүлэх, бодит социализм, энх тайван, нийгмийн дэвшлийн хүчнийг бэхжүүлэх арга замыг боловсруулахад томоохон хувь нэмэр болж байна. Лениний намын онол, улс төрийн үндсэн баримт бичигт Октябрийн эх орны коммунизмд хүрэх туйлын зорилгыг биелүүлэх арга зам түүхэн шинэ нөхцөлд ЗСБНХУ-ын баримтлах олон улсын бодлогын зорилтуудыг товлон заасан учраас ЗХУКН-ын шинэчлэн боловсруулсан программыг энх тайван, нийгмийн дэвшлийн төлөө тэмцлийн мөрийн хөтөлбөр гэж дэвшилт улс түмэн зүй ёсоор үнэлж байна.

ЗХУКН социалист орнуудын нэгдэл нягтралыг байнга бататгах нь социалист орон бүрийн болон тэдгээрийн нийтлэг эрх ашиг, энх тайвны үйл хэрэг, социализмын эрхэм дээд зорилго ялан мандахад бүрэн нийцэн нэгдгийг иш үндэс болгож байгаа юм.

«ЗХУКН ах дүү бусад намтай хамтарч социалист хамтын Нөхөрлөлийн эв нэгдлийг бэхжүүлэх, сүр хүч, нөлөөг нь улам нэмэгдүүлэх явдлыг интернационалч үүргээ гэж үзэж байна» гэж Программд дурдсан нь энэ талаар ЗХУКН-ын баримталж байгаа бодлогын үндсийг тодорхойлжээ.

Социалист орнууд эрх тэгш байх, үндэсний эрх ашгийг хүндэтгэх, улам бүр харилцан ойлгох, ойртон нягтрах замаар замнахад ЗХУКН тус дөхөм үзүүлэх болно гэдгийг Программд тэмдэглэв.

Монгол, Зөвлөлтийн ард түмний ленинч ган бат найрамдал, манай хоёр орны бүх талын хамтын ажиллагааны тулгуур эрх зүйн баримт бичиг болсон БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд найрамдал, хамтын ажиллагааны болон харилцан туслах тухай гэрээ байгуулагдсаны 40 жилийн түүхт ойг 1986 оны нэгдүгээр сарын 15-нд ах дүүгийн барилдлагааны баяр, социалист интернационализмын үзэл санааны ялалтын баяр болгож БНМАУ, ЗХУ-д ёслол төгөлдөр тэмдэглэж өнгөрүүлэв.

Энэ ойг тохиолдуулан ЗСБНХУ-ын нам, төрийн удирдлагад БНМАУ-ын удирдагчдаас илгээсэн баярын илгээлтэд «Найрамдал, хамтын ажиллагаа болон харилцан туслах тухай Гэрээ нь БНМАУ-ын аюулгүй байдлыг хангах үнэнхүү чухал хүчин зүйл, цөмийн дайныг сэрэмжлэн зайлуулах, Ази болон даян дэлхийд энх тайван, тогтвортой байдлыг сахин бэхжүүлэхийн төлөө тэмцэлд манай орнуудын олон улсын талбар дахь хамтын ажиллагаанд бат бэх үндэс болж байна››[8]. гэж найрамдлын Гэрээний олон улсын ач холбогдлыг үнэлсэн байна.

Монгол, Зөвлөлтийн ард түмний найрамдлын энэхүү гэрээ бичиг нь нийт социалист хамтын нөхөрлөлийн эрх ашигт нийцэн, Ази тив түүний бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлын төлөө нийтлэг зорилго, нийтийн тэмцэлд нэр төртэй хүчин зүйл болж ирсэн, болсоор ч байх нь эргэлзээгүй.

[8] «Үнэн» 1986 1.15.

Бидний хамтран шийдвэрлэж байгаа социалист байгуулалтын асар өргөн цар хүрээтэй асуудлыг амьдралд хэрэгжүүлэхэд дэлхий дахины энх тайван, бүх нийтийн аюулгүй байдал гол нөхцөл нь болж байна.

Империалист хүчин, тэдний гар хөл бологчдын түрэмгий явууллагын уршгаар Ази, Номхон далайн бүс нутгийн нэлээд хэсгийн байдал аюултай болж байна. Азийн энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, бүс нутгийн бүх улс орны хооронд харилцан ойлгох, итгэлцэх, энх тайван хамтын ажиллагааг хөгжүүлэх үйлсэд социалист орнууд ихээхэн хүч чармайлт гаргаж байна. Ази, Номхон далайн улсуудын хүч чармайлтыг нэгтгэх үндсэн дээр бүс нутгийн аюулгүй байдлыг хангах, энх тайван харилцааны үндсийг бататгах арга замын талаар ЗСБНХУ, БНМАУ, социалист бусад орны дэвшүүлсэн саналуудын ач холбогдол улам бүр өсч байна.

Азид энх тайван, аюулгүй байдлыг хангах, энэ өргөн уудам тивийн улс гүрний хооронд эрх тэгш, сайн хөршийн хамтын ажиллагаа тогтоохын төлөө ЗХУ, БНМАУ хэзээ ямагт тууштай идэвхтэй тэмцэж ирсэн, Тэмцсээр байна.

ЗСБНХУ, БНМАУ, социалист бусад орон, мөн эвсэлд нэгдээгүй орнуудын дэвшүүлсэн оновчтой тодорхой саналууд болон дэлхий нийтэд илэрхий «Бандунгийн зарчмууд» нь Ази тивийн түгшүүртэй байдлыг намжаах ухаалаг арга зам мөн.

Азийн энх тайван, аюулгүй байдлыг хангах асуудалд иж бүрэн хандах тухай ЗХУ-ын саналыг БНМАУ хэлбэрэлтгүй дэмжиж байгаа бөгөөд түүнийг ажил хэрэг болгоход зэвсэг хураах талаар ЗХУ-ын дэвшүүлсэн өргөн цар хүрээтэй шинэ саналууд маш чухал хувь нэмэр болно. Эдгээр шинэ саналыг хэрэгжүүлснээр Ази тивийн байдлыг үндсээр нь өөрчлөх, энэ бүс нутгийн аюулгүй байдлыг чанарын шинэ шатанд гаргахсан билээ. Ази, Номхон далайн орнуудын хоорондын харилцаанд хүч үл хэрэглэх, харилцан үл довтлох тухай конвенц байгуулах талаар БНМАУ-ын гаргасан санаачилга нь Ази, Номхон далайн бүс нутагт бат бэх энх тайван, аюулгүй байдлын систем бүрдүүлэн тогтооход салшгүй хэсэг болох ёстой гэж ЗХУ, социалист бусад орон болон Азийн энхийг эрхэмлэгч улсууд үзэж талархан дэмжиж байна.

Ази, Номхон далайн өргөн уудам бүс нутгийг сайн хөрш, энх тайван, хамтын ажиллагааны талбар болгон хувиргах нөхцөлийг бүрдүүлэх үйл хэрэгт бүс нутгийн бүх улс орныг идэвхтэй оролцуулах нь чухал юм.

БНХАУ сансрыг милитаричлахын эсрэг байр суурь баримталж, цөмийн зэвсгийг түрүүлж хэрэглэхээс татгалзах тухай мэдэгдсэн нь ЗХУ, БНМАУ, социалист бусад орны байр суурьтай нийцэж байна.

ЗХУ-ын Гадаад явдлын яамны сайд Э. А. Шеварднадзе БНМАУ-д айлчлах үеэр гаргасан Монгол-Зөвлөлтийн хамтарсан мэдэгдэлд «Хятад, улстай эрх тэгш, сайн хөрш байх зарчмын үндсэн дээр, гуравдагч орны арх ашигт хохирол учруулахгүйгээр харилцаагаа хэвийн болгон сайжруулах эрмэлзлэлтэй байгаагаа хоёр тал нотлов. Харилцааг ийнхүү сайжруулах нь Ази, Номхон далайн бүс нутгийн байдлыг эрүүлжүүлэх үйл хэрэгт тус дөхөм болохсон билээ»[9] гэж ЗХУ, БНМАУ байр сууриа илэрхийлсэн юм.

ЗХУКН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны гишүүн, ЗХУ-ын Гадаад явдлын яамны сайд Э. А. Шеварднадзе БНМАУ-д албан ёсоор найрсаг айлчилсан нь манай хоёр орны ах дүүгийн интернационалч,

[9] «Үнэн». 1986.1.26

найрамдалт харилцааг улам бүр бэхжүүлэн гүнзгийрүүлэхэд их хувь нэмэр боллоо.

Нөхөр Ж. Батмөнх: «Аугаа их Ленин, Д. Сүхбаатар нар анх үндэслэсэн бөгөөд улирах цагийн сорилт шалгалтыг даван туулсан МАХН, ЗХУКН-ын хоорондын болон монгол, Зөвлөлтийн ард түмний эвдэршгүй холбоо, ах дүүгийн найрамдал хэзээ хэзээнээс илүү бат бэх, хөдөлшгүй үндэс суурьтай, саруул сайхан ирээдүйтэй байгааг» онцлон тэмдэглэсэн билээ. Ийнхүү ЗХУ-тай тогтоосон манай холбоо, найрамдал, ах дүүгийн барилдлагаа бол социализм байгуулах замаар бидний итгэл төгс, давшингуй хөгжихийн найдвартай баталгаа болж байна.